

## МОНГОЛ УЛСЫН ХЯТАД СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ

Л.Бэгзжав\*

Олон мянган жилийн соёл иргэншлийн өвөрмөц баян өвтэй, хятадын ард түмний хэл, соёл, түүх, гүн ухаан зэрэг нийгмийн амьдрал, мэдлэгийн бүхий л хүрээг хамарсан хятад судлал нийгмийн шинжлэх ухааны нэгэн биеэ даасан салбар ухааны хувьд дэлхий дахинд эрчтэй хөгжиж байна. БНХАУ-ын олон улсын нэр хүнд, байр суурь, дэлхийн улс төр, эдийн засагт үзүүлэх нөлөө өсөн нэмэгдэхийн хэрээр хятад судлалын цар хүрээ тэлж, судалгааны агуулга, хэлбэр улам баяжсаар байна.

Дэлхийн том гүрнүүдийн нэг –БНХАУ-тай олон мянган жил айл хөрш, хил залган оршиж ирсэн Монгол улс хятад судлалын эртний уламжлал, баялаг өвтэй дэлхийн цөөн орны нэг билээ. Монголын хятад судлал хоёр орны түүхэн харилцаатай салшгүй холбоотой өвөрмөц байдлаар хөгжиж иржээ.

Хоёр орны уламжлалт харилцаанд соёлын харилцаа чухал байр суурьтай бөгөөд нүүдэлчин, суурьшмал хоёр ард түмэнд бие биенээсээ суралцсан, харилцан нөлөөлсөн түүх, соёлын, түүний дотроос орчуулгын ном зохиолын арвин их өв бий. Түүхийн эх сурвалжаас үзвэл, бүр МЭ IV зууны үед, тодруулбал Сяньби улсын эртний нэг овог Тоба улсын үеэс Хятадын эртний гүн ухааны ном зохиолоос монгол хэлэнд орчуулж байсан лавтай баримт бий.

Ляо буюу Хятан улсын үед (МЭ X-XII) хятад хэлнээс ном бичиг олныг орчуулж байсан хийгээд Күнзийн суртлын таван номын иж бүрэн орчуулга байсныг түүх сурвалжид тэмдэглэн үлдээжээ.

Өнгөрсөн түүхийг эргэн харвал, монгол орон дахь хятад судлалын үүсэл хөгжлийн түүх нь монголын түүхийн урсгалыг даган зарим үед тодорч, зарим үед бүдгэрэн хөгжиж иржээ. Монголын төрт ёсны 800 шахам жилийн түүхэн явцыг ажиглахад хятад эх сурвалж, хятадын түүх, уран зохиолын нөлөө монголын түүх соёлын түүхэнд нэлээд гүнзгий нөлөөлсөн байдаг. Монгол дахь хятад судлалын түүхийг үндсэнд нь 3 үед хувааж болох юм. үүнд:

1. XIII-XIV зууны үе буюу Юань гүрний үе. Энэ үед Хятадын уран зохиол, түүх, гүн ухаан, шашин, хууль цааз, төр ёсны олон арван зохиолыг монгол хэлнээ орчуулж хэвлэсэн юм. 1264 онд Хубилай хааны зарлигаар улсын түүх зохиох, сонгодог зохиол орчуулах тусгай хороо байгуулж байсан нь монголын бичиг соёлын түүхэнд тодорхой байр эзлэх үйл явдал байлаа. Энэ үед "Киданы түүх", "Алтан улсын түүх", "Сүн улсын түүх", "Их Юань улсын нэвтэрхий хууль", "Их Юань улсын хууль цаазын бичиг", "Ертөнцийг захирах магад хууль" зэрэг зохиолыг монгол хятад эрдэмтэд хамтран зохиосноос гадна урьд өмнө нь монгол хэлэнд орчуулагдаж байсан "Дөрвөн бичиг, таван ном" хэмээн алдаршсан олон дэвтэр номын монгол орчуулгыг хянан шүүж, дахин орчуулж байжээ.

2. XVIII-XX зууны эхэн үе буюу манж Чин улсын үе. Энэ үед Хятадын төр, иргэний олон шастир сургаал, сонгодог романуудыг орчуулан хэвлэсэн байна. Олонд нэртэй "Тансан ламын баруун этгээдэд зорчсоныг тэмдэглэсэн түүх" гэдэгт алдарт зохиолыг 1721 онд бичгийн хүн Арана хятад хэлнээс монгол хэлэнд орчуулсан нь хятадын уран зохиолын

\* Л.Бэгзжав. Монголын хятад судлаачдын холбооны ерөнхийлөгч, ШУА-ийн Зүүн Хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

орчуулгын түүхэнд гадаад хэлэнд орчуулагдсан уг зохиолын анхны орчуулга болсон байна. Үүнчлэн "Сүн улсын хүйтэн уулын бичиг", "Гурван улсын үлгэр", "Улаан асрын зүүд", "Жин пин мэй" (Алтан ваартай цэцэг) зэрэг хожмоо дэлхийд алдаршсан хятадын олон сонгодог зохиолыг хятад, манж хэлэнд орчуулсан байна. Эдүгээ ч өрнийн олон хэлэнд хараахан бүрэн орчуулагдаагүй байгаа 80 гаруй сонгодог роман, шидэт туужийг монгол хэлнээ орчуулсан ба эдгээр нь тус бүрдээ олон боть, тухайлбал зарим зохиол нь гэхэд 233 дэвтэр гэх мэт байсныг бодолцвол монгол орчуулагчид, хятадын сонгодог уран зохиолыг орчуулахын хувьд дэлхийд аль ч орноос давж гарсныг тэмдэглэлтэй.

3. XX зууны 20-иод оноос эдүгээ хүртлэх үе. 1921 онд Монгол улсад Ардын хувьсгал ялснаар тус оронд шинжлэх ухааны байгууллага шинээр бий болж, судалгаа шинжилгээний шинэ үе эхэлсэн нь энэ үеийн онцлог юм.

Энэ үеийг түүхэн он цагийн дарааллаар нь барагцаалан 4 хувааж болох юм. Тухайлбал:

1. 1921-1949 он
2. 1949-1960-аад он
3. 1960-аад оноос 1980-аад оны эхэн үе
4. 1980-аад оны эхэн үеэс одоо хүртлэх үе гэж хувааж болно.

1. 1921-1949 он бол Монгол, Хятадын харилцааны ээдрээтэй үе, өөрөөр хэлбэл хоёр, орон нийгмийн өөр өөр байгуулалтай, улс орны дотоод, гадаад нөхцөл ч өөр өөр байсан үе юм. 1921 онд Монголын судар бичгийн хүрээлэн байгуулагдаж, монголын түүхчдийн өмнө эх түүхээ сэргээн, шинээр бичих зорилт тулгарав. Монгол, Хятад хоёр орон түүхийн нэг биш үед нэгдэн нийлж дайсагнан салж, хоёр орны түүх соёлын харилцан нөлөөлөл гүнзгий байсан хийгээд нүүдэлчин, суурьшмал ард түмний онцлогоос шалтгаалан монголын түүхийн эх сурвалж гол төлөв хятад хэл дээр өвлөгдөн иржээ.

Монголын нэрт нанхиадагч Чимидийн Дэмчигдорж буюу Ч.Дандаа "Юань улсын бүрэн түүхийг" 210 дэвтэр болгон 1917-1920 онд, түр завсаргаад 1923-1928 онд ганцаархнаа хятад хэлнээс монгол хэлэнд орчуулан гаргасан нь монголын түүх бичлэгт гавьяат үйлс юм.

Ийнхүү монголын түүх бичлэг сэргэн хөгжихийн хирээр хятад судлалыг аяндаа хөгжүүлэх шаардлага тулгарч байв.

2. 1949 онд Хятадад ардын хувьсгал ялж, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноор БНМАУ, БНХАУ-ын харилцааны шинэ түүх эхлэв. Энэ үед хоёр орон социалист бүтээн байгуулалтын замаар мөр зэрэгцэн харилцан туслалцаж, хамтран ажиллаж байв. Хятадын ард түмний ололт амжилт, хөдөлмөр бүтээл, урлаг соёлыг монголын ард түмэнд таниулах ихээхэн ажил хийгдэж байлаа.

Хятадын шинэ үеийн уран зохиол, урлагийн бүтээлээс, тухайлбал Лу Синь, Ба Жин, Го Моруо нарын зохиолуудыг олноор орчуулан хэвлэж байв. Эрдэм шинжилгээ, сургалтын салбарт хамтран ажиллахын зэрэгцээ монголын олон тооны оюутан БНХАУ-д боловсрол эзэмшсэн нь тус оронд хятад судлал цаашид өрнөн хөгжих үндэс суурь болсон юм. 1960 онд Монголын нэрт хятад судлаач Ч.Далайн "Монгол дахь хятад судлал" гэсэн бэсрэг товхимол хятад хэлээр хэвлэгдэн гарсан нь монголын хятад судлалын түүх, тухайн үеийн байдлыг харуулсан анхны бүтээл байлаа.

3. 1960-аад оны эхнээс хоёр орны харилцаа тухайн цаг үеийн байдлыг дагалдан муудаж, энэ нь 1980-аад оны эхэн хүртэл үргэлжлэв. 1961 онд Монголын ШУА байгуулагдаж, шинжлэх ухааны шинэ шинэ

салбар үүсэн хөгжсөний дотор дорно дахин, олон улс судлалыг дагнан эрхэлсэн судалгааны байгууллагыг МАХН-ын Төв Хорооны тогтоолоор байгуулав. 1968 оны 5-р сарын 4-ны өдөр байгуулагдсан ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх Ази, Африк судлалын хэлтсийн Ази судлалын тасаг нь хятад судлалын эрдэм шинжилгээний судалгаа хийх болов. Тус хэлтсийн анхны даргаар хятад судлаач Ч.Далай томилогдон ажилласан юм. Энэ хэлтэс судалгааныхаа хүрээг тэлж улмаар 1976 онд Дорнодахины хүрээлэн, 1991 онд Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн болж өргөжсөн.

1978 оноос "Дорнодахины судлалын асуудал" сэтгүүлийг тогтмол хэвлэн гаргаж, хятад судлалын олон асуудлыг өргөн олон уншигчдад хүргэх болов. Тухайн үеийн социализмын улс төр, үзэл суртлын зөрөлдөөнөөс шалтгаалж, хятадын судалгааны ажил хэт улс төржиж, эрдэм шинжилгээний гэхээсээ үзэл суртлын зэвсэг болж байсан нь түүхэн үнэн юм.

4. 1980-аад оны эхэн үеэс Монгол, Хятадын харилцаа хэвийн болж сэргэснийг дагалдан монголын хятад судлалд ч шинэ их ахиц гарлаа. Хятад судлал, Монгол судлалын харилцан хамаарал бүхий сэдвээр 10 гаруй дэд доктор, докторын зэрэгтэй эрдэмтэд төрөн гарч хятадын тухай 30 гаруй эрдэм шинжилгээний ном, товхимол, өгүүллийн эмхэтгэл хэвлэн гаргав.

1990 онд Дорнодахин судлалын хүрээлэнгээс Зүүн хойт Ази судлалын төв салбарлан гарч, биеэ даасан эрдэм шинжилгээний байгууллага бий болов. Тус Төв 1992 оноос "Зүүн хойт Ази судлал" сэтгүүлийг хэвлэн гаргах болж Зүүн хойт Азийн орнууд түүний дотор хятадын улс төр, нийгэм, эдийн засгийн олон талт асуудлыг хөндсөн өгүүллүүдийг тогтмол хэвлэх болов.

Монголын ШУА-ийн дэргэд Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн, Зүүн хойт Ази судлалын төв гэсэн биеэ даасан эрдэм шинжилгээний байгууллагууд бий болсноороо энэ талын судалгааны цар хүрээ, сэдэв, нэн өргөжсөн нь монголын хятад судлалын хөгжилд шинэ ахиц болсон юм.

Судалгааны эдгээр байгууллагууд олон улс, дорнодахин, Азийн чиглэлээр өргөн хүрээтэй судалгаа явуулахын зэрэгцээ хятад судлалын чиглэлээр:

- Монголын түүхийн хятад эх сурвалжийг судлах, орчуулах
- Хятад дахь монгол судлал, монголын холбогдолтой ном, хэвлэл, сурвалж бичиг
- БНХАУ-ын гадаад бодлого, олон улсын үйл ажиллагаа, хөрш орнуудын харилцаа
- Монгол Хятадын түүхэн ба өнөөгийн улс төр, эдийн засаг
- Соёлын зэрэг харилцаа
- БНХАУ-ын шинэтгэл, түүний үр дүн сургамж
- БНХАУ-ын үндэстний өөртөө засах орнуудын түүх, соёл, нийгэм-эдийн засгийн байдал
- Зүүн хойт Азийн хамтын ажиллагаанд БНХАУ-ын эзлэх байр суурь, бүс нутгийн аюулгүй байдал
- Хятадын гүн ухаан, нийгмийн сэтгэлгээ зэрэг олон талт судалгааны ажил хийдэг.

Эдгээр хүрээлэн, төв нь олон талт судалгааны ажлын зэрэгцээ, хятад судлалын өргөн хүрээтэй асуудлаар дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээний хурлыг олонтоо зохион байгуулдаг ба мөн чиглэлээр гадаад харилцаагаа байнга өргөтгөж, дэлхийн олон орны

хятад судлалын байгууллага, эрдэмтэдтэй хамтран ажилладаг юм.

Хятад судлалын боловсон хүчинг бэлтгэх талаар манай улс анхаарч, 1980-аад оны эхнээс МУИС-д хятад хэлний анги дахин нээж хятад судлаач, хятад хэлний орчуулагч нарыг бэлтгэх болсон юм. Тус сургуулийг төгсөн гарсан хятад судлаачид ажиллаж буй тухайн салбартаа үр бүтээлтэй хөдөлмөрлөж байна. Одоо МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургууль, Гадаад хэлний дээд сургууль, Улсын багшийн их сургууль, Улаанбаатарын их сургууль зэрэг төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургуулиуд, мөн ерөнхий боловсролын 13, 38, 54-р дунд сургууль зэрэг хэд хэдэн сургуульд нийт 400 орчим оюутан, сурагч хятад хэлийг сурч байна. Хятад хэлний сургалтыг системтэй болгох, ном сурах бичгээр хангах, сургалтын нэгдсэн төлөвлөгөөтэй болох, хятад хэлний багш нарын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор 1996 оны 4-р сард Монголын Гэгээрлийн яамны дэргэд Монголын хятад хэлний багш нарын холбоог байгуулан ажиллаж байна.

1990 оны 1-р сарын 27-нд Монголын олон нийтийн үүсгэл санаачилгаар бие даасан, төрийн бус олон нийтийн байгууллага болох Монголын хятад судлаачдын холбоо (МХСХ) байгуулагдсан нь Монголын хятад судлалын шинжлэх ухаанд бас нэг шинэ хуудас нээж буй төдийгүй тус оронд хятад судлалыг цаашид хөгжүүлэхэд чухал алхам болсон юм. Тус холбоо Монголын хятад судлалын олон үеийн шилдэг уламжлалыг өвлөн уламжилж, баяжуулан хөгжүүлэх, хятад судлаач, орчуулагч, багш, ажил төрлийн хувьд БНХАУ-тай харилцаа холбоо бүхий байгууллага, хувь хүмүүсийн хүчийг нэгтгэх, ажил төрлийн уялдааг сайжруулах, улмаар Монгол, Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

МХСХ нь өмнөд хөршийнхээ шинэтгэл, эдийн засгийн бүтээн байгуулалтын туршлагаас суралцах, дэлхийн олон орны ижил төстэй зорилго бүхий эрдэм шинжилгээний байгууллага, холбоо нийгэмлэг, эрдэмтэн судлаач, багш, орчуулагч зэрэг хувь хүмүүстэй хамтран ажиллах, БНХАУ-ын өнөөгийн ололт амжилт, түүх соёл, утга зохиолоос монголын олон нийтэд танилцуулах, "БНХАУ-ыг хэн сайн мэдэх вэ? сэдэвт асуулт хариултын уралдаан зохиох, шаардлагатай мэдээ материалаар үйлдвэр, аж ахуйн газар, хоршоо компанид мэдээллээр үйлчлэх, гадаад харилцаа тогтооход нь зуучлах, хятад хэлний хэд хэдэн удаагийн сургалт зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн арга хэмжээ явуулж ирлээ.

Өнгөрсөн хугацаанд тус холбоо бие даан буюу Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн, Зүүн хойт Ази судлалын хүрээлэнтэй хамтран эрдэм шинжилгээний бага хурал, семинар, дугуй ширээний уулзалт 20-иод удаа зохион байгуулсны дотор "БНХАУ-ын шинэтгэл нээлттэй бодлогын үр дүн, туршлага", "БНХАУ ба Ази номхон далайн бүс нутаг" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулсан нь Монголд анх удаа хятад судлалын, тэр тусмаа олон улсын эрдэм шинжилгээний хурал байснаараа чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Мөн Монгол, Хятадын найрамдлын нийгэмлэгтэй хамтран, нийслэлийн төр захиргааны хэвлэл Улаанбаатар сонины тусламжтайгаар хятад судлалын чиглэлээр дагнасан анхны "Арга билиг" сониныг 1990 оны 6-р сараас 1996 он хүртэл хэвлэн гаргаж нийтдээ 33 дугаарыг нийтийн хүртээл болгов.

Сүүлийн үед тодорхой шалтгааны улмаас хэвлэн гаргахгүй байгаа ч "Арга билиг" сонин эхний жилүүддээ 10-32 мянган хувь хэвлэгдэж, хот хөдөөгийн 7500 гаруй тогтмол захиалагчтай болоод байсан юм. Энэ

сонинд Хятадын ард түмний түүх, соёл, зан заншил, утга зохиол, урлагийн бүтээлийн тухай, Хятадын эдийн засаг, нийгмийн амьдрал, хүмүүсийн ахуй амьдралын тухай зэрэг өргөн хүрээтэй сэдвээр олон арван өгүүлэл, мэдээ материал хэвлэгдэн гарсан нь өргөн олон уншигчдын талархлыг хүлээж байлаа.

Дэлхийн 5 тивийн 90 гаруй улс оронд хятад гаралтай хүн аж төрдгөөс зөвхөн Азийн 24 оронд хятадын цагаач иргэд байнга оршин сууж байна. Хятад хэл олон улсын харилцааны нэг чухал хэрэглүүр, НҮБ-ын албан ёсны 5 хэл, ажлын 6 гол хэлний нэгийн хувьд дэлхийн хамгийн түгээмэл хэл болоод байна. Иймд дэлхий дахиныг хамарсан мэдээллийн эх булгийг олж авах, ашиглахад хятад хэл онцгой үүрэгтэй юм. Иймд хятад хэлээр мэдээлэл олж авах бүхий л сувгийг ашиглах, тухайлбал холбогдох газруудтай ном, товхимол судалгааны материал, тогтмол сонин сэтгүүл зэргийг солилцох, хятад хэлний орчуулагч, судлаач нарыг сургах, мэргэжил дээшлүүлэх, хүн солилцоог идэвхтэй хийх, олон улсын хуралд тогтмол оролцох, олон орны хятад судлаачидтай байнгын харилцаатай ажиллах нь монголын хятад судлалын хөгжилд тустай байх болно.

Ялангуяа БНХАУ-ын холбогдох судалгааны байгууллагуудтай шинжлэх ухааны бүх салбарт хамтран ажиллах, судалгааг практикт өргөн нэвтрүүлэх, улс ардын аж ахуй, амьдралд үр бүтээлтэй ашиглах нь Монгол, Хятадын ард түмний найрамдал, хамтын ажиллагааг улам хөгжүүлэх, улмаар Ази, номхон далайн бүс нутгийн энх тайван, хөгжил аюулгүй байдлыг хангахад ч чухал ач холбогдолтой байх болно.

XXI зууныг "Ази-Номхон далайн зуун болно" гэж олонхи эрдэмтэд судлаачид үзэж байна. Тэр дундаа энэ бүс нутагт БНХАУ-ын эзлэх байр суурь, нөлөөг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй юм. Дэлхийн хүн амын 22 хувийг эзэлж (ОХУ-ыг үл оролцуулан) европын бүх орны газар нутагтай тэнцэх газар нутаг бүхий БНХАУ-ын улс төр, эдийн засаг, цэргийн хүчин чадал улам эрч хүчээ авч буй өнөө үед тус улстай хил залган оршдог Монгол улсын хувьд хятад судлалын ажлыг нэн идэвхтэй хийх явдал чухлаар шаардагдаж байна. Хятад судлалын шинжлэх ухааныг эрчимжүүлэн хөгжүүлэх нь зөвхөн эрдэмтэн, судлаачдын үүрэг төдий бус, төрийн бодлогын анхаарлын төвд байх ёстой асуудлын нэг мөн юм.